НАРАН РАШААН ХХК-ИЙ
ЗАХИРАЛ Г.БУД ТАНАА

ТӨВ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

41111 Төв аймаг, Зуунмод сум, Номт 1 дүгээр баг
Утас: 70273705 Цахим шуудан: emg_tuv@yahoo.com
Цахим хаяг: emg.to.gov.mn

2023.04.18 № 10-30-02/112/12

Барилга байгууламжийн зураг
төсөлд хяналт хийсэн тухай

Наран рашаан ХХК-ийн 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 1/22 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/07 дугаартай удирдамжийн хүрээнд Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасныг үндэслэн Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, дэд өртөөний барилгын ажлын дор дурдсан зураг төслийг хүлээн авч барилгын болон эрүүл ахуйн норм дүрэм, стандартуудад заасан нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэхэд эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт хийлээ. Үүнд:

1.Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн барилгын ажлын зураг,

2.Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ус хангамжийн шугам сүлжээний барилгын насос станцын барилгын ажлын зураг,

3.Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ, дэд өртөөний барилгын ажлын зураг,

Нэг. Барилга байгууламжийн талаар:

Барилга байгууламжийн зориулалт: Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, дэд өртөөний барилга нь Хоногт 200-1200м^3 хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж, 20км урттай ариутгах татуургын шугам сүлжээ, насос станцын барилга, дэд өртөөний барилгаас бүрдэнэ.

Дулаан хангамжийн байдал: Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, дэд өртөөний барилгын ажлын зураг төсөлд дулаан хангамжийн эх үүсвэрийг төвлөрсөн шугам сүлжээнээс хангуулахаар төлөвлөсөн. Халаалтын систем нь доогуур түгээлттэй 2 хоолойт мухардмал систем байна. Гол түгээх шугамыг давхрын тааз болон шалан доогуур, 32мм, салбар шугамд 20мм, 25мм голчтой хүчитгэсэн хуванцар хоолойг төлөвлөсөн.

Ус хангамж, ариутгах татуургын шугамын байдал: Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, дэд өртөөний барилгын ажлын зураг төсөлд ус хангамжийн эх үүсвэрийг төвлөрсөн шугам сүлжээнээс хангуулахаар төлөвлөсөн. Гол түгээх шугамд 50мм, салбар шугамд 20мм, 25мм голчтой хүчитгэсэн хуванцар хоолой төлөвлөсөн. Бохир усны салбар шугамд 50мм, гол цуглуулах хоолойг 100мм голчтой хуванцар хоолойг ариун цэврийн өрөөний шалан доогуур төлөвлөж өөрийн урсгалаар бохир усны насос станцын ус зайлуулах сувагт нийлүүлэн зайлуулагдахаар тус тус төлөвлөсөн. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг 50метр зайд тогтоож хашаажуулсан.

Цахилгаан хангамжийн байдал: Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ус хангамжийн шугам сүлжээний барилгын насос станцын барилгын ажлын зураг төсөлд цахилгаан хангамжийг нэгдсэн сүлжээнээс хангуулахаар төлөвлөсөн. Монгол улсын Барилга, хот байгуулалтын яамны Холболтын цэг зөвшөөрөлцөх тухай 2023 оны 01 дүгээр сарын 25-ны

412311040

өдрийн 3/271 дугаартай албан бичиг, ажлын хэсгийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 71/2022/96 дугаартай техникийн нөхцөлтэй.

Хоёр. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, дэд өртөөний барилгын ажлын зураг:

Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, дэд өртөөний барилга нь Сэргэлэн сумын 4 дүгээр багт баригдана. Хоногт 200-1200м^3 хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж, 20км урттай ариутгах татуургын шугам сүлжээ, насос станцын барилга, дэд өртөөний барилгаас бүрдэнэ.

Дэд өртөөний барилга нь тэнхлэгээрээ 6.30*11.40 метр хэмжээтэй баруун болон урд зүгт харсан гол 4 орцтой, 1 давхар барилга, дизель үүсгүүр, 10кВ-ын хуваарилах байгууламж, трансформатор №1, 0.4кВ-ын хуваарилах байгууламж, трансформатор №2 зэргээс бүрдэнэ. Гадна хана нь 380 мм зузаатнай тоосгон өрөг бүтээц хийцлэлтэй керамзит налуулгатай гадуур ус зайлуулалт бүхий хар цаасан хучилттай хавтгай дээвэртэй барилга.

Бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга нь тэнхлэгээрээ 12.00*12.00 метр хэмжээтэй газрын гадарга дээр байрлах хэсэг, газрын гадарга доор байрлах хэсэг бүхий 2 давхар барилга баруун урд болон зүүн хойд зүгт харсан гол 2 орцтой, 1 давхар барилга. Ариун цэврийн өрөө, гонх, гадна хувцас солих өрөө, ажлын хувцас солих өрөө, усанд орох өрөө, ажлын талбай,агуулах, ажлын өрөө, агааржуулалтын камер байрлуулах өрөө, цахилгааны өрөө тус тус төлөвлөсөн. Гадна хана нь 300мм зузаантай хөнгөн блок өрөг, 150мм зузаантай эрдэс хөвөн дулаалга, 20мм зузаантай шавардлага, 120мм зузаантай тоосгон өрөг бүтээц хийцлэлтэй керамзит налуулгатай гадуур ус зайлуулалт бүхий хар цаасан хучилттай хавтгай дээвэртэй барилга. Технологийн хэсгийн газрын гадарга доор байрлах хэсгийн хана нь 400мм зузаантай цутгамал төмөр бетон, 50мм зузаантай дулаалга, хар тосон түрхлэг 2 үе, шавардлагаас бүрдэнэ.

Ариутгах татуургын шугамыг давхар ханатай даацын бохир усны шугамын хуванцар хоолойгоор БУХ-1-ээс БУХ-114 дүгээр худаг хүртэл 4782.50 метр газарт 300мм голчтой хоолой, БУХ-114-өөс БУХ-180 дугаар худаг хүртэл 3235.00 метр газарт 400мм голчтой хоолой, БУХ-180-аас БУХ-214 дүгээр худаг хүртэл 19002 метр газарт 500мм голчтой хоолой, БУХ-214-өөс аваарын сан хүртэл 500мм голчтой хоолойгоор 3.10 метр газарт, БУХ-214-өөс КНС-1 хүртэл 500мм голчтой хоолойгоор 9.00 метр, БУХ-216-аас БУХ-385 дугаар худаг хүртэл 500мм голчтой хоолойгоор 10212 метр газарт, БУХ-385-аас механик цэвэрлэгээний барилга хүртэлх 400мм голчтой шугамыг 298 метр газарт байхаар тус тус төлөвлөсөн.

Гурав. Захиалагчийн нэр, хэзээ, хаана баригдах:

Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, дэд өртөөний барилгын ажлын зургийг Наран рашаан ХХК-д боловсруулсан, ерөнхий захиалагч Барилга хот байгуулалтын яамны, Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Цогтсайхан гарын үсэг зураагүй, Наран рашаан ХХК-ийн захирал Ш.Ганзориг, ерөнхий инженер Б.Амарбаясгалан нар гарын үсэг зурсан, Төв аймгийн Онцгой байдлын газрын дарга Н.Төмөрбаатар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баярхүү гарын үсэг зураагүй. Зургийн ЕГ Шифр: НР-05/2022 болно.

Дөрөв. Инженер геологийн судалгааны талаар:

Инженерийн геологийн судалгааг Инженер геодези ХХК нь Наран рашаан ХХК-тай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээг үндэслэн хийж гүйцэтгэсэн. ЗТ:11-240/17 дугаартай, Архив №22/087, Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, дэд өртөөний барилгын инженер-геологийн судалгааг 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөр хийж гүйцэтгэсэн. Судалгааны талбай нь геоморфологийн нэг элементэд барлах хурдас хуримтлагдсан зөөгдөл хуримтлалын гадаргуу. Судалгаагаар инженер-геологийн 3 төрлийн элемент илэрсэн ба ИГЭ-1 цайвар шаргалаас бор хүрэн, бор ногоон өнгөтэй, дээд ба орчин үеийн

дөрөвдөгчийн настай, хатуу хам байдалтай делюви-пролювийн гаралтай шавранцар чигжээстэй хайрган ул хөрс нь улирлын хөлдөлтийн бүсэд сул овойлт үүсгэх шинж чанартай ба ИГЭ-2 улаан хүрэнгээс улаан шаргал, бор саарал өнгөтэй, дээд ба орчин үеийн дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай хайрга агуулсан шавранцар ул хөрс нь улирлын хөлдөлтийн бүсэд дунд зэргийн хүчтэй овойлт үүсгэх шинж чанартай ба ИГЭ-3 улаан хүрэн, цайвар ногоон шаргал өнгөтэй, дээд ба орчин үеийн дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай хайрга агуулсан шавранцар ул хөрс нь улирлын хөлдөлтийн бүсэд сул овойлт үүсгэх шинж чанартай, ул хөрсний ус илрээгүй, газар хөдлөлтийн 7 баллын бүсэд хамраадаг зэргээс хамааруулан инженер-геологийн төвөгшилийн ангиллаар дунд зэргийн төвөгтэй нөхцөлд хамаарна гэж дүгнэсэн.

Тав. Барилгын ажлын зураг төсөлд илэрсэн зөрчил, дутагдлууд:

Илэрсэн зөрчил, дутагдалгүй байна.

Зургаа. Дүгнэлт:

1.Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, дэд өртөөний барилгын ажлын зураг төслийг Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНбД 30-01-04, Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж БНбД 40-02-16, Барилга доторхи усан хангамж, ариутгах татуурга БНбД 40-05-98, нормтой харьцуулан хянаж, зөвшилцсөн зураг төслийн дагуу барихад эрүүл ахуйн талаас татгалзах зүйлгүй болно.

2.Дээрх барилга байгууламжид гаргасан энэхүү эрүүл ахуйн дүгнэлт нь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын гарын үсэг зурж баталгаажсан нүүр хуудас болон улсын байцаагчийн тэмдэг дарж баталгаажуулсан хуудас

Шалгуулсан байгууллага, аж ахуй нэгж эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль зөрчигдсөн, гарсан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргах эрхтэй.

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Г.МЯГМАРСҮРЭН

ЗӨВШӨӨРСӨН:
НАРАН РАШААН ХХК-ИЙ ЗАХИРАЛ Г.БУД

Тайлбар: "Нараарашаан" ХХК-ийн инженер Б.Амарсувшин хүлээн авав.